



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 9 сарын 21 өдөр

Дугаар 4/664

Булган сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 11/08 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 23-ны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс иргэдэд эрх зүйн боловсрол олгох ажлын хүрээнд Тэшиг суманд зохион байгуулах сургалтын ажиллагаа, “Малчин таны өврийн дэвтэр” товхимол 40 ширхэгийг хэвлүүлэхэд зориулж нийт 1 273 760 (Нэг сая хоёр зуун далан гурван мянга долоон зуун жар) төгрөг зарцуулсугай.

2.Сургалт зохион байгуулах, товхимол хэвлүүлэх зардлыг “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



006323010746